



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, САНАЛ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, САНАЛ**



Ерөнхий зүйл

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 11/5087 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулжээ.

Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, яам, агентлагуудаас ирүүлсэн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулсан тухай тус баримт бичгийн төсөлтэй хамт бэлтгэн ирүүлсэн Засгийн газрын танилцуулгад мэдээлжээ.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл нь 5 бүлэг, 18 зорилт, 99 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тусгасан байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан 99 бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийтдээ 7 их наяд 311.4 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдах ба үүний 318.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 1 их наяд 541.5 тэрбум төгрөгийг гадаад эх үүсвэрээс, 5 их наяд 436.4 тэрбум төгрөгийг төр хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар, 15.4 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитын зорилт, арга зүй, хүндрэл бэрхшээл, хязгаарлалт

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд хийх аудитыг дараах зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлжээ. Үүнд:

- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх;



- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээний хүрэх түвшинг зохистой тодорхойлсон эсэх;
- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой төлөвлөсөн эсэх.

Аудитын зорилтыг хангахын тулд Түүнчлэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, салбаруудын дунд хугацааны бодлогын баримт бичгийг шалгуур болгон авч үзлээ.

Улсын Их Хурлаар 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл хэлэлцэгдэж, батлагдаагүй, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр¹ боловсруулагдаагүй, бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн дэлгэрэнгүй тооцооллыг ирүүлээгүй, шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, хүрэх түвшинг харьцуулах, шалгуур болгох хүчин зүйл дутагдалтай зэрэг шалтгааны улмаас аудитаар дэвшүүлсэн 3 дахь зорилтын хүрээнд дүгнэлт гаргахад хүндрэлтэй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоолд Үндэсний аудитын газраас үндсэн чиглэлийн төсөлд дүгнэлт өгөх чиглэл тусгагдаагүйн улмаас тус аудитыг хийх бэлтгэл хангагдаагүй, мөн цаг хугацааны хувьд шахуу, хязгаарлагдмал байдал үүссэн болно.

¹ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.-т “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулна” гэж заасан.



Аудитын дүн, дүгнэлт

Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байна

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан бодлогын 18 зорилт, 99 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон салбаруудын дунд хугацааны бодлогын болон төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн байдлыг авч үзлээ.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд нийт 18 зорилт 99 арга хэмжээний хувьд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгээс 63 төсөл, арга хэмжээ, “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс 90 төсөл, арга хэмжээ, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-өөс 23, салбаруудын бодлогын баримт бичгээс 11 төсөл, арга хэмжээнүүд тус тус давхардсан тоогоор тусгагджээ.

Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан бодлогын төсөл, арга хэмжээнүүд нь шалгуур болгон авч үзсэн дээрх хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд бүрэн нийцсэн байна.

Хоёр. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээнүүдийн хүрэх түвшинг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна

Аудитад Засгийн газрын 2016 оны 249 тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг баримтлал болгон авч үзлээ.

Дээрх журамд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг дараах шаардлагын хүрээнд нэгтгэн боловсруулахаар заасан байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх,
- Арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх.

Тогтоосон шалгуурын дагуу авч үзэхэд, 2018 оны Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээний хүрэх түвшинг хэмжигдэхүйц байдлаар хувь хэмжээ,



тоон үзүүлэлтээр илэрхийлсэн байгаа боловч хүрэх түвшингийн хэмжээг нарийвчлан тодорхойлоогүй, ерөнхийд нь авч үзсэн тохиолдол цөөнгүй байгааг залруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Авто замын салбарт замын засвар, арчлалтын асуудалд голлон анхаарч хөрөнгө хүч зарцуулж барьсан замуудын эвдрэлийг сэргээн засварлах, арчлалт хийх асуудлыг бүрхэг тусгасан байгаа бөгөөд засварлах замыг уртааш км-ээр тооцож төсөвтэй нь уялдуулах шаардлагатай ба шинээр барих 486.1 км замын уртыг байршлаар нь тооцож төсөлд тусгах нь зүйтэй байна.

Төмөр замын томоохон төслүүдээс гэрээ, хэлэлцээр нь байгуулагдсан хэрэгжих боломжтой төслүүдийг тухайн онд сонгон авч хүрэх түвшинг мөн хэмжээ, байршлаар нь нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг нэмж төлөвлөхдөө зарим хүрэх түвшинг илүү тодорхой, нарийвчлан тусгах шаардлагатай. Тухайлбал, Эгийн голын 315 мВт-ын УЦС-ын барилгын ажлыг эхлүүлэх ажлын явц 10 хувь гэж тусгасныг, илүү тодорхой болгох нь зүйтэй байна.

Эх нялхсын эндэгдлийг бууруулах чиглэлийн 4 гол үзүүлэлтүүдийг ДЭМБ-аас зөвлөсөн зохистой түвшинд хүргэх чиглэлээр тодорхой хувь², промилээр³ бууруулахаар зорилтыг тодорхой төлөвлөх шаардлагатай байна.

² хувь - 1/100мл хэмжээ

³ промил – хувийн 1/10 буюу 1/1000мл хэмжээ



Гурав. Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрэн тодорхойлоогүй байна

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан 99 бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 318.1 тэрбум, гадаад эх үүсвэрээс 1,541.5 тэрбум, Төр, хувийн хэвшлийн түншлэл /барих-ашиглах-шилжүүлэх концессын төрөл/-ээр 482.0 тэрбум, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4,954.4 тэрбум, ХЭДС, ЗХХС-аас 15.4 тэрбум төгрөг буюу нийт 7,311.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөгөөр/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	2015 он			2016 он			2017 төл.	2018 төсөл
		Төл.	Гүй.	Хувь	Төл.	Гүй.	Хувь		
1	Улсын төсөв	645.9	77.3	12.0%	233.9	202.5	86.6%	352.8	318.1
2	Зээл	66.0	106.2	160.9%					
3	Тусламж	8.0	9.4	117.5%					
4	Орон нутгийн төсөв				0.7			1.0	0.6
5	Төр, хувийн хэвшлийн түншлэл	100.0	0.0	0%	3,189.0			738.0	482.0
6	Тусгай сан	25.0	32.2	128.8%					
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				7.0	19.7	281.4%	22.5	13.0
8	Зэвсэгт хүчний хөгжлийн сан							23.1	2.4
9	Хөгжлийн банк				110.0	68.7	62.5%	57.2	
10	Хувийн хэвшил				2.5	1.0	40.0%	3,355.2	4,953.8
11	Гадаад эх үүсвэр				268.5	72.1	26.9%	825.1	1,541.5
12	Холимог эх үүсвэр				31.2	48.1	154.1%		
13	Бусад	320.0	1.8	0.6%		4.1	0%	1.3	
	Нийт	1,164.9	226.9	19.5%	3,842.8	416.2	10.8 %	5,376.2	7,311.4

Дээрх хүснэгтээс харахад эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөгөө 2015 онд 1,164.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, харин гүйцэтгэл нь 226.9 тэрбум төгрөг болж 19.5 хувьтай, 2016 онд 3,842.8 тэрбум төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл нь 4,169.2 тэрбум төгрөг болж 10.8 хувьтай тус тус гарсан байна. Харин 2017 онд 5,376.2 тэрбум төгрөгөөр батлагдаж, 2018 онд 7,311.4 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөлд тусгагджээ.

Ийнхүү жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөгөө өсөж байгаа боловч гүйцэтгэлийн хувь буурч байгаагаас харахад төлөвлөлт бодитой бус байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Тиймээс 2018 оны санхүүжилтийн төлөвлөгөө өндөр өсөлттэй (2017 оны батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 36 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн) төлөвлөгдөж байгаа нь хэрэгжих үндэслэлийн хувьд эргэлзээтэй байна.



Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн нийт эх үүсвэрийг 2017 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 1,935.2 тэрбум төгрөгөөр буюу 26.5 хувиар нэмэгдүүлж төлөвлөснөөс гадна нийт санхүүжилтийн 67.8 хувь буюу 4,953.8 тэрбум төгрөгийг хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ДНБ-ний өсөлтийг 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл -0.2 хувь, 2018 оны төсөөлөл 1.8 хувь гэж тооцоолсноос үзэхэд 2018 онд үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 7.3 их наяд буюу тухайн оны ДНБ-ний 26% буюу дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээнд төсөөлж байгаа нь хэрэгжих үндэслэл муутай байна.

Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд дараах төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэр, дүнг тодорхойлоогүй байна. Үүнд:

- **5.4.** Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барих
- **7.4.** Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх /Гангийн үйлдвэрийн барилга/
- **8.2.** Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах /Метан хийн хангамжийн мастер төлөвлөгөө/
- **15.9.** Шүүхийн шинжилгээний чанарыг дээшлүүлж, шинжилгээний бүртгэл, мэдээлэл, лавлагааны нэгдсэн тогтолцоо бий болгох /Лаборатори байгуулах- 3/
- **17.3.** Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах

Иймд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд дээрх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатай байна.

Энэхүү тайлангийн эхэнд дурдсан мэдээллийн дутагдалтай байдал, цаг хугацааны хүрэлцээгүй байдлаас шалтгаалан эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, арга хэмжээний санхүүжилтийн тооцоололд дүгнэлт гаргахад учир дутагдалтай байна.



Аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны анхааралд толилуулж байна. Үүнд:

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалт “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ”-нд үндэслэн салбар бүрийн дунд хугацааны төсвийн хөрөнгийн зардлын төсөөллийг боловсруулж байх, түүнд нийцүүлэн тухайн жилийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж, баталдаг байх;
2. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт болон салбаруудын бодлого талаас Үндэсний хөгжлийн газар, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын талаас нь Сангийн яам тухайн жилийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, Үндэсний хөгжлийн газар нэгтгэн Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх;
3. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтад тусгагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулах төсөл, арга хэмжээнд тавигдаж байгаа “нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих, 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын” гэсэн заалтыг хүчингүй болгон, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлтийн үр дүнг сайжруулах⁴;
4. Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын сангийн хооронд байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас олгогдох зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгасны үндсэн дээр Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8⁵-т заасны дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталж, түүнд нийцүүлэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан шаардлагын дагуу нягтлан үзэх;

зэрэг болно.

⁴ Төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтаар 2015 онд 427 арга хэмжээ батлагдсанаас 5 нь буюу нийт төсөвт өртгийн дүнгийн 15 хувь, 2016 онд 508 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 10 нь буюу нийт төсөвт өртгийн дүнгийн 25 хувь, 2017 онд 333 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 11 нь буюу нийт төсөвт өртгийн дүнгийн 27 хувь нь тус тус 30 тэрбум, түүнээс дээш дүнтэй төсөл, арга хэмжээнд хамаарч байна.

⁵ Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8*д “Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.” гэж заажээ.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/97


Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.39 дэх заалт, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд дүгнэлт гаргах гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралт ёсоор баталсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороонд хүргүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

[illegible]

[illegible]



- 11 -



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар 15160
Цахим хаяг: www.audit.mn